



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/009

Алтай хот

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 44 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 78.2.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан орон нутгийн өмчит нэг байгууллагын нэг барилгыг газар эзэмших эрхийн хамт, 9 нэр төрлийн автотээврийн хэрэгслүүдийг 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр нээлттэй дахин дуудлагын худалдаагаар худалдах ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Өмчийн төлөөлөгч: Ж.Билэгсайхан (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Хөтлөгч: Б.Балдорж (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Тэмдэглэл хөтлөгч: Б.Нансалмаа (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2.Нээлттэй дуудлагын худалдааг хууль, журмын дагуу ил тод зохион байгуулж, дүнг холбогдох байгууллагад танилцуулж ажиллахыг комисс (Ж.Билэгсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР